



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/124

Мандалговь

“Грийн мепл констракшн” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-2 (Дундговь, Гурвансайхан, Дэрэн, Сайнцагаан сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Грийн мепл констракшн” ХХК-тай 73,927,490 (далан гурван сая есөн зуун хорин долоон мянга дөрвөн зуун ер) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан ажлын зураг, төсвийн дагуу “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-2 (Дундговь, Гурвансайхан, Дэрэн, Сайнцагаан сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Грийн мепл констракшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Болд)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мал эмнэлгийн дарга (Ш.Мөнхдүүрэн), Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), Дэрэн сумын Засаг дарга (Н.Мядагмаа), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох) нарт ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060516